



**МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ**

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБАНЫ 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Танилцсан:

Төсвийн ерөнхийлөн захирагч

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

С.АМАРСАЙХАН

.....
(огноо)

Танилцуулсан:

Төсвийн шууд захирагч

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Ж.БУЯНБАТ

.....
(огноо)

**МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБАНЫ 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа I-IV улирал/	Хүрсэн түвшин	Биелэлт	Хувь
Нэг. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалт, хүмүүжлийн шинж чанартай нийтлэг арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх ажлын хүрээнд:									
1.1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар дундын стратеги төлөвлөгөө боловсруулах. (Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1.2 дахь хэсэг)	-	Стратеги төлөвлөгөө батлуулсан эсэх	0	1	I-III улирал	1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын салбар дундын 2027-2030 онуудад хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг энэ оны 03 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын алба, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран боловсруулах 12/02/26-07 дугаартай ажил гүйцэтгэх ерөнхий гэрээг байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Гэрээний ерөнхий хугацаа энэ оны 09 дүгээр сар хүртэл үргэлжилнэ.	100
1.2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх. (Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.1.8 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйл)	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгдсэн эсэх.	0	1	I-II улирал	0.5	Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-д “Энэ хуулийн 15.7.1-д заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэн хэрэгжүүлнэ гэж заасны дагуу Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээр гүйцэтгүүлэхээр 2026 оны 12/02/26-07 дугаартай ажил гүйцэтгэх ерөнхий гэрээг байгуулан, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх ажлын даалгаврыг хүргүүлж, мэргэжил арга зүйгээр ханган, дэмжлэг үзүүлэн холбогдох мэдээллийг нь хянан үнэлгээ хийгдэж байна. Үнэлгээний ажлын гүйцэтгэл энэ оны 07 дугаар сарын 05-ны өдөр танилцуулна.	50

1.3	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг зохицуулсан дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх санал боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх.	-	Санал хүргүүлсэн эсэх.	0	1	I улирал	1	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг даган гарах Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Засгийн газрын Тусгай сангийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиудад өөрчлөлт оруулах саналуудыг боловсруулж 2026 оны 02/44 дүгээр албан бичгээр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны А/16 тоот тушаалаар байгуулагдсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалын төсөл, мөн хуучнаар Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 хамтарсан тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслүүдийг бэлтгэж Хууль зүйн бодлогын газарт 02/218 дугаартай албан бичгээр саналуудыг хүргүүлсэн.	100
1.4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх.	-	Үнэлгээ хийгдсэн эсэх.	0	4-өөс доошгүй	I-IV улирал	1	Ажлын албаны даргын 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн салбар болон дэд зөвлөл, төрийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хийсэн ажил, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, үнэлгээ хийх ажлын төлөвлөгөөг нэмэлтээр батлан ажиллаж байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн 2026 оны үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажлыг тус Ажлын алба нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, НГХУСАЗСЗ-с шаардлагатай төсвийг шийдвэрлүүлэн Нийслэл, аймгуудын салбар зөвлөлийн үйл ажиллагааг энэ оны сүүлийн хагас жилд зохион байгуулж үнэлнэ.	100
1.5	Олон Улсын байгууллагуудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл	-	Хамтран хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн тоо	1	2	I-IV улирал	2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх - Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл “Хүйсийн тэгш эрх төв” төрийн бус байгууллагатай хамтран Канад сангийн дэмжлэгтэйгээр "Дуу хоолой-Шийдэл: Даван туулагчдын	100

	ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.							оролцоотой бодлогын зөвлөлдөх хэлэлцүүлэг", - Америкийн Нэгдсэн Улс, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан "Хүүхэд хамгааллын компакт гэрээ"-ний (ХХКГ) тав дахь удаагийн хоёр талт хэлэлцүүлэг, - АНУ-н элчин сайдын яам, "Азийн сан", "Дэлхийн Зөн Монгол" олон улсын байгууллага, - Канад улсын Засгийн газрын санхүүжилтээр Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагаас /ОУЭЗХБ/ хэрэгжүүлж буй "Монгол Улсад Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх нь" 2 дугаар шатны төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн 2025-2030 оны хооронд хамтран ажиллахаар "Харилцан ойлголцлын санамж бичиг" байгуулан ажиллаж байна.	
1.6	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ, ажлын үр дүнг цахимжуулах.	-	Цахимжуулсан эсэх.	0	1	I-IV улирал	0.6	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ, ажлын үр дүнг цахимжуулах ажлын даалгаврын төслийг боловсруулан Нийслэлийн ИТХ-ын даргын 2026 оны А/38 дугаар захирамжаар санхүүжилтийг шийдвэрлэн, 21 аймгийн салбар зөвлөлийн Ажлын албаны бүрэлдэхүүнтэй цахим уулзалтыг зохион байгуулж ажлын үр дүнг сайжруулах, цахимжуулах, хөгжүүлэх үр дүнгийн хэрэгжилтийг тооцож цахимжуулан ажиллаж байна.	60
1.7	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх.	-	Хамтран ажилласан байгууллага	6	8	I-IV улирал	8	ГХУСА33АА нь гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр:--1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба/ Хууль бус худалдааны сүлжээг тогтолцооны түвшинд шинэчлэх, таслан зогсоох төлөвлөлтийн асуудлын талаарх шинжээчдийн ажлын хэсгийн хэлэлцүүлэг/ /Цахим орчин дахь хүүхдийн бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн хэргийн материалуудыг мөрдөн шалгах чиглэлээр 25 сургагч багш бэлтгэх сургалт/, Нэгдсэн Үндэстний байгууллагын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албатай хамтран Америкийн Нэгдсэн Улсын Төрийн департаментын Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах асуудал хариуцсан олон улсын товчооны санхүүжилтээр хэрэгжиж буй "Цахим орчин дахь хүүхдийн бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлтэй тэмцэх хүрээнд дижитал мөрдөн шалгах ажиллагааны чадавхыг олон улс болон бүс нутгийн хэмжээнд бэхжүүлэх нь" төслийн хүрээнд "Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн хэргийн материалуудыг мөрдөн шалгах чиглэлээр сургагч	100

								багш бэлтгэх сургалт"-ыг энэ оны 05 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд зохион байгуулан ажилласан. Ажлын албаны судалгаагаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл бүхий 29 улсаас Үндэсний зөвлөл бүхий 9 орны ажлын алба руу цахим шуудан илгээж, гадаад хамтын ажиллагаа тогтоон ажиллаж байна.		
1.8	Зохицуулах зөвлөлийн дэргэд орон тооны бус эрдэмтэн, судлаачдын зөвлөл ажиллуулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх.	-	Шийдвэр гарсан эсэх	0	1	I улирал	1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд орон тооны бус эрдэмтэн, судлаачдын зөвлөл ажиллуулах асуудлыг судлан, судлаачдын жагсаалтыг Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран гаргаж, шаардлагатай урамшууллыг НГХУСАЗСЗ-өөс шийдвэрлүүлэн 2026 оны /2/02/26-07 дугаар Ажил гүйцэтгэх ерөнхий гэрээ байгуулан шийдвэрлэсэн.	100	
1.9	Криминологи, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлтэй холбоотой судалгааны ажлын тойм гаргах.	-	Судалгааны тайлан гаргасан эсэх.	0	1	I улирал	1	"Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн судалгааны ажлуудын хэрэгжилтийг үнэлэх судалгааны тойм" боловсруулах ажлыг Дотоод хэргийн их сургуулиар гүйцэтгүүлэхээр 2026 оны 11/01/20260066 дугаартай ажил гүйцэтгэх ерөнхий гэрээг ДХИС-тай байгуулан төсвийг шилжүүлж, "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх онол, практик" эрдэм шинжилгээний хурлыг энэ оны 05 дугаар сарын 26-ны өдөр амжилттай зохион байгуулж, хуралд төрийн болон төрийн бус байгууллагын 120 төлөөлөл, зочид оролцон, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орчны загварчлал, цагдаагийн криминологи, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх босоо болон хэвтээ удирдлага зэрэг 11 сэдвээр эрдэмтэн судлаачид илтгэл хэлэлцүүлэн амжилттай зохион байгуулсан. Криминологи, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол практикийн хурлын эмхэтгэл буюу судалгааны ажлын тоймыг нэгтгэн 2026.05.28-ны өдөр хэвлэн гаргасан.	100	
Хоёр.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, түүнийг хэрэгжүүлэх талаар Салбар болон Дэд зөвлөлийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн цогц арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх ажлын хүрээнд:										
2.1	Зохицуулах зөвлөлийн хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан зохион байгуулах, Зохицуулах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	83	85	I-IV улирал	85	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026.03.03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулан зөвлөлийн гишүүн байгууллагуудад албан бичгээр хүргүүлсэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн даргаас өгсөн	100	

	хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах, хуралдаанаас гарсан шийдвэр төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах. (Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ын 5.2)						чиглэлийн дагуу хагас жилийн ажлын тайлангийн биелэлтийг тооцохоор энэ оны 05 дугаар сарын 04-ний өдөр 02/174 дугаартай албан бичгийг 10 яам, 22 байгууллагуудад хүргүүлж, ирүүлсэн биелэлтүүдийг нэгтгэж, Зохицуулах зөвлөлийг хуралдуулах хуралдааны бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Аймгуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн эхний хагас жилийн тайлан мэдээг авч нэгтгэхээр энэ оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 02/235, 02/234 дугаартай албан бичгүүдийг хүргүүлсэн.		
2.2	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан зохион байгуулах, үндэсний хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах, хуралдаанаас гарсан шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах. (Засгийн газрын 2022 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны ажиллах журам”)	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90	91	I-IV улирал	91	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хорооны 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлуулан гишүүн байгууллагуудад хүргүүлсэн. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хорооны дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдаас өгсөн үүргийн дагуу Үндэсний хорооны ээлжит хуралдааныг зохион байгуулах, байгууллагуудын мэдээлэлтэй танилцах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эхний 6 сарын байдлаар зохион байгуулсан ажлын биелэлтийг нэгтгэсэн. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Улсын Их Хуралд 2026 оны 03 дугаар сард өргөн мэдүүлж, энэ оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, 06 дугаар сарын 04-ний өдрийн Улсын Их Хурлын хуралдаанд танилцуулсан.	100

2.3	<p>Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн Удирдах зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хуралдаан зохион байгуулах, сангийн хөрөнгөөс санхүүжүүлэх 2026 оны төлөвлөгөөг боловсруулан хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах, хуралдаанаас гарсан шийдвэр, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах. (Засгийн газрын 2024 оны 149 дүгээр тогтоол “Дүрэм, журам шинэчлэн батлах тухай”)</p>	Сангийн хөрөнгө	Санхүүжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	8.8	100	I-IV улирал	100	<p>Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангаас 2026 онд санхүүжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл болон сангийн удирдах зөвлөлийн анхдугаар хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг танилцуулах, 2025 онд санхүүжүүлсэн арга хэмжээний тайлан танилцуулах, сангийн удирдах зөвлөлд орохоор хүсэлт ирүүлсэн байгууллагын талаар хэлэлцэхээр төлөвлөн холбогдох төслүүдийг боловсруулан, хурлын товыг мэдээлэхээр шийдвэр хүлээж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2025 оны ТГ/600 дугаартай албан бичгээр Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн Удирдах зөвлөлийн гишүүн “Эрүүл Монгол Хүн” төсөл хөтөлбөрийн албаны дарга О.Чимэдсүрэн нь өөр албан тушаалт томилогдсон тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эрүүл мэнд, нийгмийн бодлогын зөвлөх Б. Бадамцэцэгийг сангийн удирдах зөвлөлийн гишүүнээр өөрчлөн томилуулах санал ирүүлсэний дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын “Эрүүл Монгол Хүн” төсөл хөтөлбөр хариуцсан албаны дарга гэснийг “Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрүүл мэнд, нийгмийн бодлогын зөвлөх” гэж өөрчлөх төслийг боловсруулан хүргүүлж, Засгийн газрын 2026 оны 75 дугаар тогтоолоор өөрчлөгдсөн.</p>	100
2.4	<p>Хүчирхийллийн эсрэг үндэсний хорооны хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан зохион байгуулах, Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах, хуралдаанаас гарсан шийдвэр төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах.</p>	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	85	I-IV улирал	85	<p>Хүчирхийллийн эсрэг үндэсний хорооны анхдугаар хуралдааныг зохион байгуулж, 2026-2030 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг 57 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 12 ажил, арга хэмжээ нь тодорхой төсөв шаардагдахаар тусгагдаж, 40 ажил арга хэмжээ нь улсын төсөв болон шаардлагатай төсвөөс зохион байгуулахаар боловсруулж, тус хорооны гишүүдэд болон Төлөвлөгөөний төслийг энэ оны 06 дугаар сарын 05-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлсэн.</p>	100

	(Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 48 дугаар захирамж)								
2.5	Хүн худалдаалахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах. (Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйл)	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	82.7	85	I-IV улирал	85	Хүн худалдаалахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, гишүүн байгууллагуудад албан бичгээр хүргүүлсэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан ба Хүчирхийллийн эсрэг үндэсний хорооны 2026-2030 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд хохирогчдыг түр хамгаалах байр, хамтарсан баг ажиллуулах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлуудыг тусгаж оруулсан. Хүн худалдаалахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахаар энэ оны 06 дугаар сарын 23-ны өдөр хуралдааныг хийхээр бэлтгэл ажлыг бүрэн хангасан.	100
2.6	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах. (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйл)	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	87.1	88	I-IV улирал	88	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, энэ оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор дэд зөвлөлийг шинэчлэн байгуулсан мэдээллийг гишүүн байгууллагуудад албан бичгээр хүргүүлсэн. Хүчирхийллийн эсрэг үндэсний хорооны 2026-2030 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд хохирогчдыг түр хамгаалах байр, хамтарсан баг ажиллуулах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлуудыг тусгаж оруулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хангах ажлын хүрээнд энэ оны 05 дугаар сарын 06-ны өдөр Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан багийн II улирлын уулзалтыг зохион байгуулж, хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, хохирогч хүүхдэд үзүүлж буй үйлчилгээ, тулгамдсан асуудал болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцон, холбогдох байгууллагуудад тодорхой үүрэг чиглэл өгч, урт хугацааны сэтгэл заслын үйлчилгээний хамтын ажиллагааг өргөжүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн Хүүхдийн төлөө	100

								үндэсний зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээнд хамаарах тайлан мэдээллийг бэлтгэж энэ оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 02/210 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.	
2.7	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах. (Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.2)	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	84	86	I-IV улирал	86	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөл, Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийг байгуулсан 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн “Дэд зөвлөл байгуулах тухай” 01 дүгээр тогтоолыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор хүчингүй болгосон. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны	100
2.8	Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах. (Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.2)	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	80	81	I-IV улирал	81	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор дэд зөвлөлүүдийг шинэчлэн баталсан ба Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлүүдийн бүрэлдэхүүнийг шинэчилж батлаагүй. Ажлын албанаас Экологийн цагдаагийн алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагатай Хүрээлэн буй орчны эсрэг, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажиллаж байна.	100
2.9	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.	50.0	Үйлчилгээ авсан хүүхдийн тоо	0	5-аас доошгүй	I-IV улирал	4	Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөл “Хүйсийн тэгш эрх төв” ТББ-тай хамтран Канад сангийн дэмжлэгтэйгээр “Дуу хоолой-Шийдэл: Даван туулагчдын оролцоотой бодлогын зөвлөлдөх Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн салбар дундын хамтарсан багийн хэлэлцүүлэгт энэ оны 05 дугаар сарын 06-ны өдөр оролцож, 2026 оны эхний 4 сарын байдлаар бүртгэгдсэн хохирогч хүүхдүүдийн 4 тохиолдолд үзүүлсэн үйлчилгээтэй танилцаж, хамгаалалт, сэтгэл заслын болон боловсролын үйлчилгээг сайжруулах чиглэл, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцож, дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Одоогийн байдлаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, сум, баг, хорооны хэмжээнд гэр	100

								бүлийн хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хамтарсан 764 багт, нийт 6000 гаруй гишүүн ажиллаж байна.	
Гурав.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас санхүүжүүлэх үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан ажил арга хэмжээний хүрээнд:									
3.1	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүргийн хууль сахиулах байгууллагад чухал шаардлагатай багаж хэрэгслээр судалж, хангах.	20.0	Хангасан багаж хэрэгсэлийн тоо	0	1 багц	I-IV улирал	1	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүргийн хууль сахиулах байгууллагад чухал шаардлагатай багаж хэрэгслээр хангах, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд 2026 онд батлагдсан төсвөөс 2025 онд үүссэн гэрээгээр худалдан авах ажиллагааны үлдэгдэл төлбөрийг төсвийн хуваарийн өөрчлөлт хийн барагдуулсан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүргийн хууль сахиулах байгууллагад чухал шаардлагатай багаж хэрэгслээр хангах ажлын хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг тандах тест болон Nionscan 600 төхөөрөмжийг худалдан авахаар судалж үнийн судалгааны ажлыг хийсэн.	100
3.2	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулах чиглэлээр мэргэжлийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.	50.0	Сургалт, соён гэгээрүүлэх ажлын явц, гүйцэтгэлээр	0	3	I-IV улирал	3	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 29 дүгээр тогтоолын 1.2 дахь хэсэгт "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг хууль бусаар Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх асуудлыг таслан зогсоох зорилгоор гадаад улс, Олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллах"-ыг холбогдох байгууллагуудад даалгасан. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Бүгд Найрамдах Казахстан Улсын нийслэл Астана хотноо 2026 оны 02 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, түүний угтвар болон химийн бодис, тоног төхөөрөмжийн хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба, Төв Азийн Бүс Нутгийн Мэдээлэл Зохицуулалтын Төв (ЦАРИКЦ)-өөс зохион байгуулсан олон улсын хуралд Монгол Улсаас НГХУСАЗСЗ-н төлөөлөгчид оролцоход холбогдох мэдээлэлээр хангаж тоо баримт, судалгааг гаргаж өгсөн. Ажлын албанаас Хэнтийн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран "Хүрээлэн буй орчин, мал хулгайлах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс	100

							<p>урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх нь” сэдэвт зүүн бүсийн уулзалт, хэлэлцүүлгийг энэ оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Хэнтий аймгийн Чингис хаан хотод Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн ерөнхий прокурор, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, байгаль орчин, газар тариалангийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, орон нутгийн цагдаагийн газрын дэд дарга, холбогдох алба хаагчдаас бүрдсэн 9 байгууллагын 60 гаруй төлөөлөл оролцуулан зохион байгуулсан.</p> <p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиг үүргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр Монголын донтох эмгэг судлаачдын нийгэмлэг ТББ-тай хамтран Япон улсын донтох эмгэгийн судлаачдыг урьж энэ оны 09 сард сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан.</p>	
3.3	Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хохирогч хамгаалалын үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх.	50.0	Хамгаалагдсан хохирогчийн тоо	5	5-аас доо шгүй	I-IV улирал	<p>4</p> <p>Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшигт Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хийсэн ажлын тайлан, хохирогч хамгааллын чиглэлээр хийж буй ажлын мэдээг гаргаж энэ оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 02/207 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/156 дугаар тушаалаар Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үзүүлэх салбар дундын хамтарсан багийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталсаны дагуу Хохирогч олон байгууллагаар дамжин үйлчилгээ авах, үйлчилгээний давхцал, хийдэл үүсэх, аюулгүй байдал, нөхөн төлбөр, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр үе шаттай зохион байгуулалтын арга хэмжээ авч байна. Үүнд:</p> <p>1-р үе шат: Үнэлгээний ажлыг гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө, аргачлал, шалгуур үзүүлэлт, ярилцлагын удирдамж боловсруулж, захиалагчаар батлуулах;</p> <p>2-р үе шат: Батлагдсан төлөвлөгөөний дагуу ХХГХ-ийн хохирогчийг таньж тогтоох, үйлчилгээний зураглал, хүртээмжийн үнэлгээний судалгаа хийх;</p>	100

							<p>3-р үе шат: Үнэлгээний үр дүн, дүн шинжилгээ, бодлогын зөвлөмж боловсруулж, хэлэлцүүлэг зохион байгуулан, эцсийн тайланг захиалагчид хүлээлгэн өгөх. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн тогтолцоо, хүртээмж, уялдаа холбоо, санхүүжилт, хэрэгжилтийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, хохирогч төвтэй, практикт хэрэгжүүлэх боломжтой “Нэг Хаалга”-ны үйлчилгээний загвар болон бодлогын, хууль эрх зүйн зөвлөмжийг хамтран боловсруулан ажиллаж байна. Энэ оны 05 дугаар сарын 06-ны өдөр Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан багийн II улирлын уулзалтыг зохион байгуулж, энэ оны 04 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн 4 тохиолдолд үзүүлсэн үйлчилгээтэй танилцаж, хамгаалалт, сэтгэл заслын болон боловсролын үйлчилгээг сайжруулах чиглэлээр санал солилцон дэмжлэг үзүүлсэн.</p>		
3.4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Сэргийлэгч” нэвтрүүлэг бэлтгэж, олон нийтэд хүргэх.	-	Нэвтрүүлэг бэлтгэж, олон нийтэд хүргэх ажлын явц, гүйцэтгэлээр	6	6-аас доо шгүй	I-IV улирал	3	<p>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр богино хэмжээний 3 видео, 3 рейлийг цувралаар хүргэсэн. “Сэргийлэгч” зорилтот нэвтрүүлгийг бэлтгэж, олон нийтэд хүргэхэд зарцуулах зардлын төсөв шийдвэрлээгүй тул олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх ажил гүйцэтгэх гэрээг хийгээгүй болно. Цаашид зардлын асуудлыг шийдвэрлэж нэвтрүүлгийг бэлтгэн олон нийтэд түгээн ажиллахаар судалж байна.</p> <p>Мөн энэ оны 05 дугаар сарын 28-ны өдөр тус ажлын албанаас ХЗДХЯ-ны харьяа агентлаг, байгууллага болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан, алба хаагчидтай уулзалт хийж, Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар танилцуулж, цаашид хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцлоо.</p> <p>Мөн салбарын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах нэгжүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудын шийдвэрлэх арга замын талаар ярилцаж, туршлага хуваалцав.</p>	100

3.5	“Гэмт хэргийн цагаан ном-2025” эмхтгэлийг бэлтгэн гаргах ажлыг зохион байгуулах.	-	Бэлтгэл ажлын явц, гүйцэтгэлээр	0	1	I-IV улирал	1	“Гэмт хэргийн цагаан ном-2025” эмхэтгэлийг бэлтгэн гаргах ажлыг Дотоод хэргийн их сургуулиар гүйцэтгүүлэхээр 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр 11/01/20260066 дугаартай ажил гүйцэтгэх ерөнхий гэрээг байгуулж, Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсвөөс санхүүжилтийг шийдвэрлүүлсэн. “Гэмт хэргийн цагаан ном-2025” эмхтгэлийг бэлтгэн гаргах ажлыг Дотоод хэргийн их сургуультай хамтран Улсын Дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулан зохион байгуулалтын арга хэмжээ авч, Ажлын хэсгээс энэ оны 07 дугаар сард урьдчилсан байдлаар эмхтгэлийн агуулгыг танилцуулахаар ажиллаж байна.	100
Дөрөв.Тодорхой этгээд гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор түүний зан үйл, ёс суртахуунд нөлөөлөх, түүнээс гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгах, түүний улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирох эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд:									
4.1	ЕБС-ийн 10-12 дугаар ангийн сурагчид, их, дээд сургуулийн эрх зүйн бус мэргэжлийн ангийн 1, 2 дугаар дамжааны оюутнууд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад эрх зүйн мэдлэг олгох албан бус сургалтыг үргэлжүүлэн зохион байгуулах.	-	Эрх зүйн мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийн дагуу ажлын явц, гүйцэтгэлээр	5000	6000	I-IV улирал	6000	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс өсвөр насны хүүхэд, залуучуудыг урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд боловсролын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2026 онд 21 аймгийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг чадавхжуулах “Бүсчилсэн сургалт”-ыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Тус сургалтыг зохион байгуулахтай холбоотой зардлыг шийдвэрлүүлэх ажлын хүрээнд ГХУСАЗЗАА-наас “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/73 дугаар тушаалаар байгуулагдсан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт хүргүүлээд байна. Улсын хэмжээнд 17 аймгийн 172 сумын 6000 ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хууль эрх зүйн мэдлэг олгох, үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх сургалтыг Аймгууд дахь салбар зөвлөлд үүрэг өгч зохион байгуулсан.	100

								Цагдаагийн ерөнхий газар, Дотоод хэргийн Их сургуульд ажлын чиглэл хүргүүлж Сонсогчдыг хүүхдийн зуслан дээр дадлага хийлгэх, тэдэнд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж байна.	
4.2	Аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг нэгтгэж, дүгнэх, удирдлагад танилцуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх. (Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэгдсэн тайлан, мэдээ гаргах, түүнд дүн шинжилгээ хийх болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг үнэлэх журам")	-	Салбар зөвлөлийн гэмт хэргээс урьдчилан чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын явц, гүйцэтгэлээр	0	22	II, IV улирал	19	Аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг нэгтгэж, дүгнэх, удирдлагад танилцуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр энэ оны 05 дугаар сарын байдлаар Улсын хэмжээнд Нийслэл болон 18 аймаг дахь салбар зөвлөлүүдээс 182 суманд ажиллаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, төрийн албан хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан мэдээг нэгтгэн Төрийн нарийн бичгийн даргад энэ оны 05 дугаар сарын 11-ний өдөр танилцуулсан. Боловсролын яам, Эрүүл мэндийн яаманд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүргүүлсэн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аймаг, Нийслэлийн салбар зөвлөлүүдэд хүргүүлсэн. Мөн Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Аймгуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн эхний хагас жилийн тайлан мэдээг авч нэгтгэхээр энэ оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 02/235, 02/234 дугаартай албан бичгүүдийг хүргүүлсэн. Биелэлтийг Засгийн газрын 2020 оны 192 дугаар тогтоолыг баримтлан энэ оны 07 дугаар сарын 05-ний дотор нэгтгэн дүгнэж удирдлагад танилцуулан мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхээр ажиллаж байна.	100
4.3	Гэмт хэргийн статистик мэдээллийг холбогдох байгууллагаас нэгтгэн авч, улирал тутам удирдлагыг мэдээллээр хангах, инфографик, бэлтгэн олон нийтэд хүргэх.	-	Гэмт хэргийн статистик мэдээллийн тоо	0	16	I-IV улирал	5	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба нь Цагдаагийн ерөнхий газраас сар бүр гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээллийг нэгтгэн авч, гэмт хэргийн өсөлт, бууралтыг инфографикаар үзүүлж, аудио тайлбартайгаар иргэд, олон нийтэд түгээж, танилцуулж байна. 2026 оны эхний 1-5 сарын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг зөвлөлийн цахим хуудаст нийтэлсэн. 1. https://www.facebook.com/share/v/1G8gMe3BW5/?mibextid=wwXlfr	100

								<ul style="list-style-type: none"> 2. https://www.facebook.com/share/v/1DuVRBYzpD/?mibextid=wwXlfr 3. https://www.facebook.com/share/v/1DLvEyJLHy/?mibextid=wwXlfr 4. https://www.facebook.com/share/v/1Kres7a5We/?mibextid=wwXlfr 5. https://www.facebook.com/share/v/1GiWYUjcc9/?mibextid=wwXlfr 	
4.4	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд “Байгалиа хамгаалъя” олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, гүйцэтгэлээр	0	1	II улирал	1	“Байгалиа хамгаалъя” нэгдсэн арга хэмжээг тус Ажлын алба нь Экологийн цагдаагийн албатай хамтран 2026 оны 05 дугаар сарын 24-ний өдөр “Иргэн бүр экологич” уриан дор Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд байгаль орчныг хамгаалах үйлсэд иргэн бүрийн оролцоо, хариуцлага чухал болох талаар онцлон байгаль эх дэлхийгээ хамгаалахад хувь нэмрээ оруулахыг уриалж олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. Энэхүү нэгдсэн арга хэмжээг энэ оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх 45 хоногийн хугацаатай үргэлжлүүлэн зохион байгуулан дүнг нэгтгэн ажиллана.	100
4.5	Тодорхой төрлийн гэмт хэрэг (судалгаанд үндэслэн цахим хэлбэрээр үйлдэгдэж буй гэх мэт), зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон соён гэгээрүүлэх чиглэлээр подкаст, рийл, постер бэлтгэж олон нийтэд түгээх.	-	Инфографик, шторк, контент, цуврал нэвтрүүлэг тухай бүр бэлтгэн, олон нийтэд түгээх ажлын явц, гүйцэтгэлээр	0	36	I-IV улирал	16	Ажлын албанаас тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгээр рийл, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд цувралаар 5 рийл, хуурамч согтууруулах ундаа, хүүхдийн хүнд хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий постерууд, аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх ажлын хүрээнд 4 рийл бэлтгэж, цахим хуудсаараа түгээн ажиллаж байна. Цахим /ccsr.gov.mn/ хуудаст байршуулсан. www.familycenter.mn цахим хуудсаар дамжуулан 2026 оны 3 дугаар сарын 8-наас 18-ны өдрүүдэд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хүүхэд рүү чиглэсэн контент бэлтгэж, иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэж, түгээсэн. Үүнд: Постер-7, Хэлэлцүүлэг-1, Тэнгэр телевизээр “Эмэгтэйчүүдийн эрх ба бодит байдал” сэдэвт панел хэлэлцүүлэг Подкаст: “Эцэг эх ба хүүхэд” сэдэвт подкаст зэрэг нийт 9 ажил, арга хэмжээг зохион байгуулан ажиллав. Нийт хандалтын тоо 12.649 байна.	100


Тав.Ажлын албаны үйл ажиллагааны дотоод зохион байгуулалт, ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг зохицуулж, тэдний нийгмийн баталгааг хангах, ажиллах хэвийн нөхцлийг бүрдүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд									
5.1	Монгол улсын төсөв, санхүүгийн холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ажлын албаны стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтыг биелүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүгийн зохистой харьцааг хангаж ажиллах.	Улсын төсөв	Холбогдох хууль тогтоомж, судалгаанд үндэслэн тодорхойлсон байх.	1,1 тэрбум	1,1 тэрбум	I-IV улирал	1	Ажлын албанд 2026 онд нийт 1.1 тэрбум төгрөгний төсөв батлагдсан бөгөөд Төсвийн тухай хуулиар зарцуулалтыг хийж, гүйцэтгэлийн тайлан мэдээг сар бүрийн эхэнд гаргаж Төрийн санд тайлагнаж байна. Одоогоор цалинд 224,520.9 төгрөг, Нийгмийн даатгалд 11,596.1 төгрөг, бараа хангамжийн материалд 4,595.5 төгрөг, дотоод томилолтын зардалд 680.0 төгрөг, нийтлэг ажил үйлчилгээний төлбөрт 141,746.0 төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшуулалд 400.0 төгрөг, Хар тамхи мансууруулах бодистой тэмцэх хөтөлбөрт 88,580.0 төгрөг, Хүн худалдаалахтай тэмцэх хөтөлбөрт 16,900.8 төгрөгний гүйцэтгэл гарсан байна. 2025 онд тендер болон шууд худалдан авалтууд хийж жилийн эцэст 242,1 сая төгрөгний өртэй байсан бөгөөд 2026 оны төсвөөс хуваарийн өөрчлөлт хийлгүүлэн гэрээт байгууллагуудын өрийг төлж барагдуулан өнөөдрийн байдлаар өрийн үлдэгдэлгүй бна.	100
5.2	Ажлын албаны анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, үндсэн хөрөнгө болон бараа материалын хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавих, санхүүгийн зөрчил, дутагдалгүй ажиллах.	Улсын төсөв	Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн ажил, гүйцэтгэлээр	0	Санхүүгийн зөрчилгүй байна.	I-IV улирал	1	Сар бүр нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13, 14-р зүйлд үндэслэн бүрдүүлж, баримтын бүрдлийг ханган баримтыг архивын нэгж болгон хадгалах, мөн жилд хоёр удаа бараа материал болон хөрөнгийн тооллого хийж, хяналт тавин ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/36 дугаар тушаалаар батлагдсан Хууль зүй, дотоод хэргийн салбарын Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах тооллогын комисс байгуулах тушаалын дагуу Ажлын албаны эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулж биелэлтийг тооцон энэ оны 07 дугаар сарын 09-ний дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэхээр ажиллаж байна.	100
5.3	Төсвийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд Шилэн дансны сайтад мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж ажиллах.	Улсын төсөв	Байршуулсан мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	151 /100	151/100	I-IV улирал	151/100	Сар бүрийн 6-ны өдрийн дотор Shilendans.gov.mn сайтад төсвийн байгууллагын төсөв гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан, санхүүжилтийн орлого, зарлагын дэлгэрэнгүй мэдээлэл, тушаал шийдвэрийг ил тод болгон 68 төрлийн мэдээллийг оруулан тайлагнасан.	100

5.4	Ажлын албаны 2027 оны төсвийн төсөл, 2028-2029 оны төсвийн төсөөлөл боловсруулж холбогдох газруудад хүргүүлэх.	Улсын төсөв	Ажлын албаны 2027 оны төсвийн төсөл, 2028-2029 оны төсвийн төсөөлөл боловсруулж хүргүүлэх ажлын явц, гүйцэтгэлээр	0	2	II улирал	2	Ажлын албаны 2027 оны төсвийн төсөл, 2028-2029 оны төсвийн төсөөлөл боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2026 оны 07 дугаар сарын 05-ны дотор хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2027 оны төсвийн хязгаарт тусгах саналыг 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 02/229 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн.	100
5.5	Албан хаагчдыг холбогдох сургалтад хамруулж, тогтмол чадавхжуулах.	Улсын төсөв	Сургалтын тоо	8	10	I-IV улирал	4	Тус ажлын албаны 4 алба хаагчийг төрийн болон орон нутгийн өмчөөр ажил, бараа, үйлчилгээ худалдан авах ажиллагааны АЗ сургалтад энэ оны 03 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд хамруулж гэрчилгээ олгосон . Жил бүрийн гуравдугаар сарын дөрөв дэх долоо хоногийн пүрэв гарагт Зарлан мэдээллийн дуут дохиогоор ажиллах төлөвлөгөөний дагуу 2026 оны 03 дугаар сарын 27-ны пүрэв гарагийн 16:00 цагт гамшгийн аюулын дуут дохиог тус ажлын албаны 8 алба хаагч оролцсон. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг хууль зүйн салбарын хэмжээнд хэлэлцэж, хэн нэгнийг хүйсийн шинж чанараар ялгаварлахгүй байх, хүн бүрт тэгш боломж олгох зарчмыг таниулах зорилготой салбарын шинээр томилогдон ажиллаж буй ажилтан, албан хаагчдад зориулсан сургалтад Ажлын албаны 5 албан хаагч 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хамрагдсан. Хууль зүй, дотоод хэргийн салбарын сургалтын нэгдсэн бодлого /2027-2030/ боловсруулах, суурь судалгаанд тус ажлын албаны албан хаагчид хамрагдаж судалгааг Төрийн захиргаа, удирдлагын газарт энэ оны 05 дугаар сарын 14-ний өдөр хүргүүлсэн болно.	50
5.6	“Алба хаагч бүрд орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд 1-ээс доошгүй алба хаагчийг хамруулах.	-	Орон сууцны дэмжлэг үзүүлсэн албан хаагчийн тоо	0	1	I-IV улирал	0.5	Ажлын албаны алба хаагчдыг “Алба хаагч бүрд орон сууц хөтөлбөр”-т хамруулахаар ХЗДХЯ, ШШЕГ-аас мэдээллийг авч Хан-Уул дүүргийн 8 хороо Архивын ерөнхий газрын зүүн талд шинээр баригдаж буй орон сууцны төлбөрийн нөхцлийг орон сууцны дэмжлэг үзүүлэхээр 8 алба хаагчдад танилцуулахад сарын төлөлтийн график нь богино хугацаанд төлөгдөх тул одоогоор саналыг хүлээн авч квотод орох хүсэлт гаргаагүй болно.	100

5.7	Ажлын албаны архив, албан бичиг хэрэг хөтлөлт, гэрээ, тушаалуудын бүртгэл, өргөдөл, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдлыг хариуцан ажиллах.	Улсын төсөв	Шийдвэрлэлтийн хувь	100	100	I-IV улирал	100	Ажлын албанд өнөөдрийн байдлаар 343 албан бичиг ирснийг холбогдох албан хаагчид цохолт хийж, хариутай албан бичигт хяналт тавин ажиллаж байна. Тус ажлын албанаас нийт 323 албан бичиг шийдвэрлэж, төрийн болон төрийн бус байгууллагуудад хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Одоогоор 20 албан бичгийг шийдвэрлэхээр судлан ажиллаж байна.	100
Дундаж хувь									96

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА

НОТЛОМЖ ХАВСРАЛТУУД:


МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Бага тогрову, Б.Шар ноёнмын гудамж 8/4,
Засгийн газрын V байр,
Утас: 260095, Факс: (976-11) 260042

2026.01.26 № 02/44
тантай _____-ны № _____-т


Санал хүргүүлэх тухай


Тус Ажлын албанаас "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1.Хуулийн төслийн 45 дугаар зүйлийн 45.10-т "... Ажлын албаны чиг үүргийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14.2-т заасан Ажлын алба хэрэгжүүлнэ." гэснийг "... Ажлын алба нь хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний дэргэд ажиллах бөгөөд орон тооны ажлын албатай байна." гэж өөрчлөх.

2.Хуулийн төслийн 45 дугаар зүйлийн 45.11-т "Үндэсний хорооны орон тооны ажлын албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан нь төрийн албан хаагч байх бөгөөд албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно." гэж тусгах болно.

Үндэслэл: Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн Чиглэл хүргүүлэх тухай 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн н/77 дугаар албан бичиг.

Хүндэтгэсэн,
ДАРГА  Ж.БУЯНБАТ




МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Бага тогрову, Б.Шар ноёнмын гудамж 8/4,
Засгийн газрын V байр,
Утас: 260095, Факс: (976-11) 260042

2026.05.25 № 02/118
тантай _____-ны № _____-т

Санал өгөх тухай

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16 тоот тушаалаар байгуулагдсан "Хуулиар эрх олгосон заалтыг бууруулах, хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хэсэг"-ээс өгсөн чиглэлийн дагуу Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалын төслийг боловсруулж хүргүүлэв.

Мөн таниас ирүүлсэн энэ оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 6/2381 дугаартай албан бичгийн дагуу хуучнаар Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 хамтарсан тушаалаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн томъёолол хэлбэрээр бэлтгэж хавсаргасан болно.

Хүлээн авч, танилцана уу.
Хавсралт 19 хуудастай.

Хүндэтгэсэн,
ДАРГА  Ж.БУЯНБАТ




152640342
Alban bichin A4

Хавсралт 1.5 "Дуу хоолой-Шийдэл: Даван туулагчдын оролцоотой бодлогын зөвлөлдөх хэлэлцүүлэг"



Хавсралт 1.6 Ажлын албанаас 21 аймгийн салбар зөвлөлийн Ажлын албаны бүрэлдэхүүнтэй хийсэн цахим уулзалт



Хавсралт 1.9 "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх онол, практик" эрдэм шинжилгээний хурал



Хавсралт 1.9 "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх онол, практик" эрдэм шинжилгээний хурал



Хавсралт 1.7 "Хууль бус худалдааны сүлжээг тогтолцооны түвшинд шинэчлэх, таслан зогсоох төлөвлөлтийн асуудлын талаарх шинжээчдийн ажлын хэсгийн хэлэлцүүлэг



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ





МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АНЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ



United Nations
Office on Drugs and Crime



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АНЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ





U.S. DEPARTMENT of STATE





EXPERT WORKING GROUP ON M...







ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ



№	Гарчиг	Линк	Зураг	Хандалт
1	2026 оны 1 сарын гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээлэл	https://www.facebook.com/share/v/1BpuiFoJAC/?mibextid=wwXlfr		Лайк-28 Шейр-26 Үзэлт-1027
2	2026 оны 2 сарын гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээлэл	https://www.facebook.com/share/v/19mRLRB2Si/?mibextid=wwXlfr		Лайк-23 Шейр-14 Үзэлт-1520

3	2026 ОНЫ 3 САРЫН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭЛЛИЙГ ХҮРГЭЖ БАЙНА	https://www.facebook.com/share/v/1Zw8yY5aop/?mibextid=wwXlfr		<p>Лайк-20 Шейр-14 Үзэлт-1361</p>
ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ КОНТЕНТ				
1	<p>МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ</p>	https://www.facebook.com/share/r/18Z44m6e26/		<p>Лайк-32 Шейр-17 Үзэлт-1257</p>

2	Хуулийн этгээд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар дараах нийтлэг үүрэг хүлээнэ	https://www.facebook.com/share/r/1PHxoziB91/?mib_extid=wwXlfr		Лайк-26 Шейр-33 Үзэлт-932
3	Цахим орчинд байршуулсан хямд үнэтэй, гарал үүсэл тодорхойгүй, хуурамч байж болзошгүй архи, согтууруулах ундаа худалдан авахаас сэргийлээрэй	https://www.facebook.com/share/p/1BCMvXawfD/		Лайк-32 Шейр-86 Үзэлт-1340

4	<p>“Тэжон хотын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орчны дизайны үндсэн төлөвлөгөө, гарын авлага”-ыг танилцууллаа.</p>	<p>https://www.facebook.com/share/v/18L7JDAxNe/</p>		<p>Лайк-81 Шейр-13 Үзэлт-2766</p>
